



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/58

Өвт

Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дахь заалт, Улсын Онцгой Комиссын даргын 2020 оны 4 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж"-ийн 10, Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ын 2.4, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Бат-Өлзий сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлсүгэй.

2. Засаг даргын Тамгын газрын ажлын тусгай горимын үед ажиллах цагийн хуваарийг ажлын өдрүүдэд үдээс өмнө 09.00 цагаас 12.00 цаг, үдээс хойш 14.00 цагаас 16.00 цаг хүртэл ажиллахаар тогтоосугай.

3. Ажлын тусгай горимд шилжсэн үеийн цалин, хөлсийг бүрэн олгож, цаг бүртгэлийг цаасаар бүртгэн, өдөр тутмын ажилд хяналт тавьж, шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010115